

**ШИНЭ МОНГОЛ ТЕХНОЛОГИЙН
ДЭЭД СУРГУУЛИЙН
ЧАНАРЫН ГАРЫН АВЛАГА**

2023 он

АГУУЛГА

УДИРТГАЛ.....	3
НЭР ТОМЬЁО БА ТОДОРХОЙЛОЛТ.....	5
ШМТДС-ИЙН ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТОГТОЛЦООНЫ ХАМРАХ ХҮРЭЭ ...	7
ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ЗОРИЛГО	7
ЧАНАРЫН ТОДОРХОЙЛОЛТ	7
ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН АРГУУД.....	8
ЧАНАР ШАЛГАХ АРГА	9
ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ҮР ДҮН	10
ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД	11
ДЭЭД БОЛОВСРОЛЫН ЗАСАГЛАЛ БА МАНЛАЙЛАЛ.....	11
СТРАТЕГИЙН МЕНЕЖМЕНТ БА ТӨЛӨВЛӨЛТ	12
СУРГАЛТЫН ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТ	13
ҮЙЛДВЭРИЙН ОРОЛЦОО.....	16
ГАДААД БА ДОТООД ҮЙЛЧИЛГЭЭ.....	17
ШМТДС-ИЙН ЧАНАРЫН БОДЛОГО.....	17
ШМТДС-ИЙН ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО.....	17
ШМТДС-ИЙН ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ	19

УДИРТГАЛ

Шинэ Монгол Технологийн Дээд Сургууль (цаашид ШМТДС гэх) нь стандарт, чанар гэсэн ойлголтууд манай сургуулийн хөгжлийг тодорхойлох ойлголтууд гэж үздэг. Олон улсын тэргүүлэх их дээд сургуулиудын стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллах нь сургалт судалгааны ажлын чанарыг тасралтгүй сайжруулах байгууллагын соёлыг бий болгох, сургалт судалгааны ажлын үр ашгийг тогтмол нэмэгдүүлэх боломжтой юм. Өнөө үед стандарт хэрэглэдэггүй нэг ч улс орон, нэг ч их дээд сургууль байхгүй. Ямар нэгэн зүйлийг өөр зүйлтэй харьцуулахад хамгийн сайн зүйл нь стандарт байдгийг хүн бүр мэднэ. Иймд хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагыг хангахгүйгээр, стандарт хэрэглэхгүйгээр ямар ч сургалт судалгааг чанартай явуулах боломжгүй юм.

Гадаадын ихэнхи их дээд сургуулиуд чанарын тогтолцооны олон улсын ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлж энэ стандарт шаардлагад нийцүүлж өдөр тутмын үйл ажиллагаандаа (Төлөвлө-Хий-Шалга-Сайжруул) PDCA үйл явцын аргыг хэрэглэх болсон. Ямар ч байгууллага PDCA мөчлөгийн арга ашигласнаар ямар ч үйл явцыг зохих удирдлага, хангалттай нөөцөөр хангах, улмаар сайжруулах боломж бүрдэх болсон. 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан Дээд боловсролын тухай хуульд “Дээд боловсролын чанарын баталгаажуулалт нь сургуулийн сургалт, судалгааны гүйцэтгэлийн болон чанарын удирдлагыг сайжруулах зорилготой, нээлттэй, оролцогч талыг хамарсан тасралтгүй үйл ажиллагаа байна” гэж заасан.

ШМТДС нь 2017 оноос эхлэн Сургалтын албанд чанарын баталгаажуулалт хариуцсан мэргэжилтэн ажиллуулж эхэлсэн. 2022 оны 11-р сард ШМТДС-ийн бүх багш, ажилтан “Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын тогтолцоо” сэдэвт сургалтанд хамрагдсан. 2023 оны 01 сарын 31-ний А/06 өдрийн тоот захирлын тушаалаар чанарын баталгаажуулалтын алба байгуулсан. 2023 оны 08 сарын 28 –ны өдрийн Б/12-1 тоот захирлын тушаалаар чанарын баталгаажуулалтын албаны бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Шинэчлэн батлагдсан Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлд нийцүүлэн 2023 оны 10-р сард ШМТДС-ийн Чанарын гарын авлагыг боловсруулан хэвлүүлж бүх багш ажилтны гарын авлага болгон хэрэглүүлж байгаа билээ.

ШМТДС-ийн Алсын хараа

“Монголынхоо их дээд сургуулиудыг манлайлж жишиг их сургууль болох”

ШМТДС-ийн Эрхэм зорилго:

“Эх орноо хөгжүүлэх дэлхийд үнэлэгдэх энтрепренер инженерийг орчин үеийн сурганы аргаар бэлтгэх”

ШМТДС-ийн Уриа:

“Улс орны ирээдүй хүний хөгжлөөс хүний хөгжил чанартай боловсролоос”,

“Мэдлэгээ бүтээгдэхүүн болгоё”

ШМТДС-ийн Үнэт зүйлс:

“Эзэн сэтгэл, талархах сэтгэл, шинэ монголын алтан гурвалжин, академик эрх чөлөө, бүтээлч чанар”

- Сургуулийн бүхий л үйл ажиллагаанд эзэн сэтгэлээс хандах,
- Бусдад туслах, талархах сэтгэлээс өрөөлд аз жаргал бэлэглэх, өөрийн аз жаргалыг дархалж явах,
- Бие бялдарын боловсрол, зүрх сэтгэлийн боловсрол, мэдлэгийн боловсрол нь Шинэ Монгол Технологийн Дээд Сургуулийн алтан гурвалжин гэж нэрлэгдэх үнэт зүйлс,
- Улс төрөөс хараат бус байх зарчмаар сургалт, судалгааны үйл ажиллагаагаа явуулах академик эрх чөлөөг дээдлэх,
- Мэдлэгээ бүтээгдэхүүн, бүтээл болгох бүтээлч чанартай байх.

ШМТДС-ийн стратеги төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлүүд нь ШМТДС-ийн алсын хараа, эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

ШМТДС-ийн тэргүүлэх чиглэлүүд:

1. Сургалтын ажлын шинэчлэл
2. Судалгааны ажлын шинэчлэл
3. Гадаад, дотоод хамтын ажиллагаа
4. Сургуулийн санхүүгийн шинэчлэл
5. Боловсон хүчний шинэчлэл
6. Маркетинг ба мэдээлэл зүйн шинэчлэл
7. Менежментийн шинэчлэл

НЭР ТОМЬЁО БА ТОДОРХОЙЛОЛТ

Аудит- Аудитын шалгуур ямар хэмжээнд биелсэн болохыг тодорхойлохын тулд аудитын нотолгоо олж авах, бодитойгоор үнэлэх, баримтжуулах үйл явц;

Байгууллагын төлөв байдал - Байгууллагын зорилтуудыг томъёолох, түүнд нөлөөлж болох дотоод болон гадаад хүчин зүйлсийн шинжилгээ, дүгнэлт;

Баримтжуулсан мэдээлэл - Мөрдөж буй, хөтөлж буй, хадгалж буй зохих мэдээлэл;

Боловсролын үйлчилгээ: багшлах, суралцах болон судлах үйл явцаар оюутанд мэдлэг, ур чадвар, хандлага эзэмшүүлэх үйл явц;

Бодлого - Дээд удирдлагаас албан ёсоор илэрхийлсэн байгууллагын алсын хараа, эрхэм зорилго;

Бүтээгдэхүүн - Батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулж диплом, гэрчилгээ, сертификат олгож байгаа бүх төрлийн боловсролын үйлчилгээний үр дүн;

Гаралт: Үйл явцын гарц, үр дүн;

Гүйцэтгэл - Хэмжиж болохуйц үр дүн;

Дотоод аудит - Стандартын шаардлагад нийцэж байгаа болон эс нийцэж байгаа байдлыг тогтоох баримтжуулсан үйл явц;

Дүн шинжилгээ - Тогтоосон зорилгод хүрэхэд тохиромжтой эсэх, хангалттай, үр нөлөөтэй болохыг тодорхойлох үйл ажиллагаа;

Залруулга - Гарсан алдаа буюу үл тохирлыг засаж сайжруулсан арга хэмжээ;

Залруулах арга хэмжээ - Гарсан алдаа болон үл тохирлын учир шалтгаан, нөхцөл байдлыг тодорхойлж, дахин гаргахгүй байх арга хэмжээ;

Нийгмийн хариуцлага - Байгууллагын ил тод, ёс зүйтэй байдлаар өөрийн шийдвэр, үйл ажиллагааны нийгэм болон байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний төлөө хүлээх хариуцлага нь:

- Эрүүл мэнд, нийгмийн сайн сайхан байдал зэрэг тогтвортой хөгжлийн дэмжлэг;
- Сонирхогч талуудын итгэл найдварыг харгалзах байдал;
- Хамаарах хууль эрх зүйн шаардлага болон олон улсын хэм хэмжээний нийцэл;
- Байгууллагын хэмжээнд нэгтгэж, гадаад дотоод харилцаа холбооны хүрээнд хэрэгжүүлэх

Сонирхогч тал - Сургуулийн үйл ажиллагаанд нөлөөлж оролцогч хүн буюу байгууллага;

Стандарт - Тодорхой салбарт үйл ажиллагааны оновчтой хувилбарыг бий болгоход чиглэгдсэн, нийтлэг дахин давтан хэрэглэгдэх журам, ерөнхий

зарчим буюу төлөв байдлыг тогтоосон, зөвшилцлийн үндсэн дээр боловсруулагдсан эрх бүхий байгууллагаас баталсан баримт бичиг;

Тасралтгүй сайжруулалт - Гүйцэтгэлийг сайжруулах дахин давтагдах үйл ажиллагаа;

Тогтолцоо - Харилцан хамааралтай эсвэл харилцан үйлчлэл бүхий элементүүдийн багц;

Үйл явц - Төлөвлөсөн үр дүнд хүрэхийн тулд оролтыг гаралт болгон хувиргах харилцан хамаарал бүхий багц үйл ажиллагаа;

Үл тохирол - Дүрэм, журам хэрэгжихгүй байх буюу тогтоосон шаардлага үл биелэх байдал;

Үр нөлөө - Төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хүрсэн байдлын хэмжээ;

Хэрэглэгчийн сэтгэл ханамж - Хэрэглэгчийн хүлээлт биелэгдсэн хир хэмжээний талаарх хэрэглэгчийн ойлголт;

Чанарын удирдлагын тогтолцоо - Байгууллагыг чанарт хамаарах асуудлаар удирдан чиглүүлэх ба хянах удирдлагын харилцан уялдаа буюу харилцан үйлчлэл бүхий багц үйл явц;

Чанар - Багц үзүүлэлт нь шаардлагыг биелүүлэх, хангах хир хэмжээ;

Чанарын гарын авлага: Чанарын бодлогыг багтаасан байгууллагын чанарын баталгаажуулалтын тогтолцоонд зориулсан гарын авлага;

Чанарын баталгаажуулалтын тогтолцоо: Чанарын бодлого, зорилтуудыг тодорхойлох, тэдгээр зорилтод хүрсэн эсэхэд үнэлгээ хийх, хэрэгжүүлэх үйл явцад хяналт тавих, үл тохиролд залруулга хийлгэх, сайжруулалт хийх багц үйл явц;

Чанарын баталгаажуулалт - Чанарын шаардлага хангагдана гэсэн итгэл бий болгоход чиглэсэн чанарын удирдлага;

Чанарын сайжруулалт - Чанарын шаардлагуудыг хангах чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн чанарын удирдлага;

Шаардлага - Нийтээр зөвшөөрсөн хэрэгцээ ба хүлээлт;

Эрсдэл-Тодорхой бус байдлын үр нөлөө;

ШМТДС-ИЙН ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТОГТОЛЦООНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Чанарын баталгаажуулалтанд ямар нэгэн үйл явцыг зохион байгуулах, манлайлах, стратеги төлөвлөлт хийх, үйл явцын болон хөтөлбөрийн хэрэгжилтэнд мониторинг, дотоод хяналт хийх, гүйцэтгэлд үнэлгээ ба сайжруулалт хийх, оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа хийх үйл явцууд хамрагдана.

Чанарын баталгаажуулалтын хүрээ дараах зүйлсээс бүрдэнэ. Үүнд:

- Чанарын баталгаажуулалтын зорилго
- Чанарын тодорхойлолт
- Чанарын баталгаажуулалтын аргууд
- Чанарыг шалгах аргууд
- Чанарын баталгаажуулалтын үр дүн

ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ЗОРИЛГО

Чанарын баталгаажуулалт нь хоёр гол зорилготой байна. Үүнд:

- **Хариуцлагын зорилго (оролт, гаралт):**
 - Хариуцлагын зорилгод хүрэхийн тулд сургуулийн тэргүүлэх чиглэлүүдэд тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийг баримтлах
 - Байнгын сайжруулалтыг хийхийн тулд улирал бүрт явцын сайжруулалт хийх
 - Хариуцлагын тогтолцоог бий болгохын тулд эцсийн үр дүнг үнэлгээний аргаар үнэлэх
- **Сайжруулах зорилго (үйл явц):**
 - Сургуулийн тэргүүлэх чиглэлүүдэд тогтоосон шалгуур үзүүлэлтүүд болон үйл явц нь чанарыг сайжруулах орчин нөхцөл, сэдэл нь байх
 - Тасралтгүй сайжруулалт хийх замаар ирээдүйн чанартай гүйцэтгэлийг бий болгох
 - Явцын үнэлгээний аргаар хяналтыг биш чанарыг сайжруулах

ЧАНАРЫН ТОДОРХОЙЛОЛТ

Дээд боловсролын чанар нь хамрах хүрээ, оролцогч талуудын шаардлагуудын олон хэмжигдэхүүнээс хамаарах тул нэг чанарын тодорхойлолт хэрэглэхгүй.

Хамрах хүрээ: Элсэгчдийн чанар, сургах үйл явцын чанар, төгсөгчдийн чанар
Оролцогч талууд: Оюутан, багш, ажилтан, төгсөгч, ажил олгогч, засгийн газар

Чанарын тухай дараах тодорхойлолтуудыг хэрэглэнэ.

Зорилгод тохирсон чанар: Сургууль зорилгоо хэрэгжүүлж чадах эсэхэд үнэлгээ хийх үйл явц. Чанарын энэ ойлголт бүхэлдээ сургуулийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэнэ.

Босго шалгуурын чанар: Чанар нь өөрөө хангагдах ёстой босго шаардлага байна. Чанарын энэ ойлголт нь магадлан итгэмжлэлийн дүгнэлтийн суурь үзүүлэлт болдог.

Нэмэгдсэн үнэ цэнийн чанар: Сургалтын явцад оюутанд нэмэгдсэн үнэ цэнийг хэлнэ. Чанарын энэ ойлголт нь төгсөгчдөд гарах үр дүнгээр илрэх чанарыг илэрхийлнэ.

Мөнгөний үнэ цэнийн чанар: Сургуулийн санхүүгийн үр ашгаар илэрхийлэгдэнэ.

Оролцогч талуудын сэтгэл ханамж: Чанарын энэ ойлголт нь тухайн нэг үйл явц “Оролцогч талуудын хүлээлтэд хүрсэн” үед тухайн зүйл чанартай болсныг илэрхийлнэ.

ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН АРГУУД

Чанарын баталгаажуулалтанд дараах гурван аргыг хэрэглэнэ:

- **Чанарын магадлан итгэмжлэл:** Тухайн байгууллага эсвэл хөтөлбөр нь босго стандартыг болон тодорхой нэг шалгуурыг хангаж байгаа эсэхэд хийсэн үнэлгээ,
- **Чанарын үнэлгээ:** Энэ арга нь чанарыг тоо, оноо, үсэг гэх мэт дүнгээр үнэлсэн үнэлгээ,
- **Чанарын аудит:** Чанарын аудит нь байгууллага өөрийн зорилтуудаа хир хэмжээнд хэрэгжүүлж байгаад хийх үнэлгээ.

1. Чанарын магадлан итгэмжлэл

- Магадлан итгэмжлэл дээд боловсролын байгууллага болон хөтөлбөр босго стандартыг болон тодорхой нэг статусын шалгуурыг хангаж байгаа эсэхэд үнэлгээ хийдэг.
- Магадлан итгэмжлэлийн чиглэл нь дээд боловсролын байгууллага эсвэл хөтөлбөрийн эрхэм зорилго, нөөц, үйл явцыг дэлгэрэнгүй шалгадаг.
- Магадлан итгэмжлэлийн үр дүнд нь тийм/үгүй шийдвэрт хүргэдэг.
- АНУ-д хөтөлбөрийн болон байгууллагын магадлан итгэмжлэл нь үндсэн чанарын баталгаажуулалтын арга байдаг.

2. Чанарын үнэлгээ

- Үнэлгээ бол чанарын талаар дүнгээр үнэлгээ хийдэг, хоёр сонголтоос нэгийг нь сонгодог магадлан итгэмжлэлээс өргөн цар хүрээтэй үнэлгээ юм.
- Үнэлгээ “таны гаралт хэр сайн байна вэ” гэсэн асуултыг тавьдаг.
- Үнэлгээний гаралт нь үнэлгээний дүн байдаг боловч чанарын магтаал болон санал байж болно.
- Хөтөлбөрийн чанарын үнэлгээг Европын их сургуулиудад хамгийн өргөн хэрэглэдэг.

3. Чанарын аудит

- Чанарын аудит нь байгууллага өөрийн шууд эсвэл шууд бус зорилтуудаа хир хэмжээнд хэрэгжүүлж байгааг шалгадаг.
- Чанарын аудитыг 3 үйл явцаар шалгана.
 1. Дэвшүүлсэн зорилтуудтай холбоотойгоор төлөвлөсөн чанарын үйл явцын тохирол,
 2. Төлөвлөгөөтэй хийгдэх бодит чанарын үйл ажиллагаануудын тохирол
 3. Дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилготой үйл ажиллагаануудын үр дүн
- Аудит таны үйл явц хир үр дүнтэй байна вэ гэсэн асуулт тавьдаг.
- Аудитын үр дүн дээд боловсролын байгууллагуудын зорилтуудын аль нь зөв байсныг харуулдаг.

- Академик аудитыг байгууллагын түвшинд хэрэгжүүлдэг.
- Чанартай сургах, суралцахуйг баталгаажуулах, сайжруулахын тулд дээд боловсролын байгууллага хэрэгжүүлсэн үйл явц руу аудит чиглэж ажилладаг.
- Европт байгууллагын аудитыг чанарын баталгаажуулалтын гурван байгууллагын нэг нь хэрэглэдэг.

ЧАНАР ШАЛГАХ АРГА

Чанарыг шалгах үед гурван үндсэн аргыг хэрэглэнэ:

- Өөрийн үнэлгээ
- Ижил төрлийн байгууллагын үнэлгээ
- Хөндлөнгийн үнэлгээ

Энэ гурван үнэлгээ нэг нэгнээ үгүйсгэдэггүй. Зарим чанарын байгууллагууд өөрийн үнэлгээг хийсний дараа ижил төрлийн байгууллагаар үнэлгээ хийлгээд улмаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэдэг.

1. Өөрийн үнэлгээ - Ихэнх чанарын үнэлгээнд өөрийн үнэлгээ гол элемент байдаг.

- Энэ арга нь дээд боловсролын байгууллагууд гүйцэтгэлийн болон чанарын шалгуур үзүүлэлтийн багцаар өөртөө үнэлгээ хийж, хэмжихийг дэмждэг.
- Энэ арга нь дээд боловсролын байгууллагууд өөрийн стратегийн эрхэм зорилго, зорилтуудаа хэр хэрэгжүүлж байгаагаа шалгахад тусалдаг бөгөөд цаашдын хөгжилд чиглэсэн сайжруулалтын төлөвлөгөөг бэлтгэх боломжийг бүрдүүлж өгдөг.
- Ялгаатай байж болох боловч олон дээд боловсролын байгууллагууд өөрийн үнэлгээг хийдэг. Жишээ нь: АНУ-ын их сургуульд магадлан итгэмжлэлийн явцад өөрийн үнэлгээг хийдэг олон жилийн уламжлалтай.
- Дээд боловсролын байгууллагууд өөрийн үнэлгээг хийхэд нь дэмжлэг үзүүлэхийн тулд зааварчилгаа, гарын авлагаар зайлшгүй хангаж өгөх ёстой.

2. Ижил төрлийн байгууллагын үнэлгээ: Энэ нь нэг салбарын өөр академик байгууллага үнэлгээ хийхийг хэлдэг.

- Эрдмийн судалгаанаас гадна сурах, суралцахуйц үнэлгээнд ижил байгууллагын үнэлгээ өргөн хэрэглэх болжээ.
- Энэ арга нь дээд боловсролын байгууллагын адил салбарт хүлээн зөвшөөрөгдсөн багш, удирдлагатай тохирох “ижил” байгууллагыг олох явдал байдаг.
- Энэ аргыг хэрэглэсэн үед ижил түвшний багш нар, удирдлагыг урьж баримт бичгийн үнэлгээ хийлгэж, талбар дээр ажиллан, оролцогч талуудаас ярилцлага авдаг.

3. Хөндлөнгийн үнэлгээ: Мэргэжлийн суурь, ажлын туршлагаар нь хөндлөнгийн үнэлгээний гишүүдийн шинжээчийг сонгож томилохыг хэлнэ.

- Шинжээч гишүүд нь үндэсний болон гадаадын нэр хүндтэй эрдэмтэд, профессорууд байхаас гадна үйлдвэрийн салбарын академик биш гишүүд байна.
- Шинжээч гишүүд дээд боловсролын байгууллагын бэлтгэж өгсөн баримт бичигт үнэлгээ хийж, тухайн орчинд ажиллаж, ажилтнууд болон оюутнуудтай уулзаж, оролцогч талуудтай ярилцлага хийнэ.

ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ҮР ДҮН

Чанарын баталгаажуулалтын үр дүнг 3 янзаар тайлагнана:

- Чанарын баталгаажуулалтын үнэлгээний тайлан
- Мөшгөх үйл ажиллагаа
- Үнэлгээг санхүүжилттэй холбох

1. Чанарын баталгаажуулалтын үнэлгээний тайлан

- Чанарын баталгаажуулалтын үнэлгээг сургуулийн болон хөтөлбөрийн тайланд тусгана.
- Чанарын баталгаажуулалтын үнэлгээний тайлан доорх агуулгатай байна:
 - а) Шинжилгээ болон үр дүн
 - б) Нотолгоо
 - в) Сайшаал
 - д) Санал
 - е) Дүгнэлт
- Чанарын баталгаажуулалтын үнэлгээний тайланг эцэслэж, эрх мэдэл бүхий удирдлагад танилцуулахаас өмнө үнэн зөвийг тодруулах үүднээс урьдчилсан тайланг дээд боловсролын байгууллагад танилцуулна.

2. Мөшгөх үйл ажиллагаа

- Чанарын баталгаажуулалтын үйл явц нь ихээхэн цаг, нөөц шаардсан ажил тул албан ёсны мөшгөх үйл ажиллагааг дагаж мөрдөх нь чухал байдаг.
- Зохицуулалт хийх эрх бүхий байгууллага үнэлгээний үйл ажиллагааг доорх байдлаар удирдан явуулах үүрэг хүлээнэ:
 1. Дээд боловсролын байгууллага тайланд өгсөн санал зөвлөмжид албан ёсны хариуг бэлтгэж, албан бичгээр хүргүүлнэ.
 2. Дээшлүүлсэн асуудлыг шийдэх, санал зөвлөмжийг хэрэгжүүлэхийн тулд ажил сайжруулах төлөвлөгөө төсөв боловсруулж илгээнэ (төсөл)
 3. Сайжруулах төлөвлөгөө үр дүн, цагийн төлөвлөгөө гол үе шатууд дуусах хугацааг оруулж өгнө.
 4. Сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын тайланг өгнө.
 5. Сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад шаардлагатай бол явцын үнэлгээ хийнэ.

3. Чанарын үнэлгээг санхүүжилттэй холбох

- Маргаантай асуудал бол дээд боловсролын байгууллагын санхүүжилт нь бүхлээрээ эсвэл хагас нь үнэлгээний үйл явцын үр дүнд суурилсан эсэх асуудал байдаг.
- Чанарын үнэлгээ нь санхүүжилтийн шийдвэртэй ихэнх тохиолдолд холбоотой байдаг.
- Чанарыг санхүүжилттэй холбох үндэслэл нь илүү хариуцлагатай болох, сайжруулалт хийх хүсэл зоригийг өгөх явдал байдаг.
- Энэ нь үйл ажиллагааг сайжруулан шилдэг болгох зорилготой бөгөөд ажлын гүйцэтгэлийн түвшинг өсгөх сайжруулах сэдлийг нэмэгдүүлж өгдөг.

ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД

1. Дээд боловсролын засаглал ба манлайлал
2. Стратегийн менежмент ба төлөвлөлт
3. Сургалтын чанарын менежмент
4. Аж үйлдвэрийн оролцоо
5. Үйлчилгээ (гадаад ба дотоод)

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ЗАСАГЛАЛ БА МАНЛАЙЛАЛ

Дээд боловсролын засаглал гэдэг нь дээд боловсролын байгууллага албан ёсны зохион байгуулалтад орж өөрийн зорилт, эрхэм зорилго, алсын хараагаа хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулахыг хэлнэ. Үүнд:

Сургуулийн эрхэм зорилго, алсын харааг тогтоох, хэвшүүлэх;
 Сургуулийн стратегийн тэргүүлэх чиглэлүүдийг тогтоох;
 Стратегийн тэргүүлэх чиглэлүүдийг хэрэгжүүлэх менежменттэй болох;
 Тохирох засаглалын зохион байгуулалтыг загварчлах;
 Нөөцтэй холбоотой мэдлэг, дүн шинжилгээ, дүгнэлт хийсэн байх;
 Менежмент хариуцсан багийг томилох, хяналт тавих;
 Удирдах зөвлөлийг байгуулах, дүрэмтэй байх;
 Сургуулийн баримт бичгийн боловсруулалт, бүртгэл, хяналтын журамтай байх.

Дээд боловсролын манлайлал гэдэг нь нийтийн өмнө тавигдаж байгаа зорилгод хүрэхийн тулд бусдадаа нөлөөлж, тэднийг хойноосоо дагуулж, урагшлах чиглэлийг тодорхойлж, улмаар тодорхой ажил хийх итгэл үнэмшлийг төрүүлж, хүмүүсийг өөрийнхөө үйл ажиллагааны үр дүнг хариуцдаг болох чадварыг хэлнэ. Үүнд:

Манлайллын амжилтыг бүрдүүлэх;
 Үндсэн оролцогч талууд хариуцлагатай байж сурах (гэрээ байгуулсан байх);
 Сургуулийн байр суурийг бэхжүүлэх;

Дээд боловсролын сайн засаглалын 5 гол зарчим:

- Сургууль өөрийн гаргасан шийдвэрийн үр дагаварыг мэдээлэх, тайлбарлах, хариулах үүрэгтэй байх;
- Сургуулийн нийт хамт олон шийдвэр яаж, яагаад гарсныг бүрэн ойлгох, дагаж мөрдөх боломжтой байх;

- Шийдвэр нь сургуулийн бодлого, бизнес дүрэм журам, үйл явц, үнэт зүйл, соёлтой нийцэж байх;
- Цаг үед тохирсон оновчтой хариу арга хэмжээ болохуйцаар өрсөлдөн буй олон сонирхлын тэнцвэрийг хадгалж, олон нийт, эдийн засаг, үндэсний хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлагад шилжих ёстой;
- Бүх гол оролцогч тал өөрт хамааралтай шийдвэр гаргах үйл явцад оролцоход ижил боломжтой байх.

СТРАТЕГИЙН МЕНЕЖМЕНТ БА ТӨЛӨВЛӨЛТ

Менежмент нь төлөвлөлтөөс хэрэгжүүлэх хүртлэх ерөнхий үйл явц бөгөөд дүрэм журмаар заасан хүрээнд бодлого, төлөвлөгөө, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглүүлж сургуулийн эрхэм зорилго, алсын хараатай уялдуулан стратегийн төлөвлөгөө, удирдлагын бүтцийг зохион байгуулж нөөцөөр хангаж, удирдах үүрэгтэй. Сургууль нь урт хугацааны амжилтын төлөө стратегийн менежментийг хэрэгжүүлнэ.

Стратеги төлөвлөгөөг бий болгох алхамууд:

1. Байгууллагын алсын хараа, эрхэм зорилгыг тодорхойлох;
2. Гадаад, дотоод хүчин зүйлсийг авч үзэж SWOT гэх мэт дүн шинжилгээ хийх;
3. Стратегийн чиглэл, зорилгыг тодорхойлох;
4. Стратегийн зорилт, түүнд хүрэх төлөвлөлт, KPI (key performance indicator) буюу гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтийг боловсруулах;
5. Стратеги төлөвлөгөөг хэлэлцүүлж сайжруулах.

Байгууллагын бүтэц, зохион байгуулалт

Байгууллагын бүтэц, зохион байгуулалт нь чиг үүргийн харилцааг тогтоох байгууллагын албан ёсны арга тул чиг үүргүүдийг хэн хариуцаж ажиллахыг тогтоож өгнө. Ингэснээр байгууллагын ажлыг хялбар болгоход чиглэнэ. Байгууллагын бүтэц, зохион байгуулалтын үндсэн төрлүүд:

1. Дээрээс доош чиглэсэн бүтэц: Хамгийн түгээмэл уламжлалт бүтэц бөгөөд шаталсан байдлаар ажилладаг.
2. Матриц бүтэц: Ажилтнууд дарга болон төслийн менежерт ажлаа тайлагнах байдлаар ажилладаг тул төсөлд суурилсан байгууллагад тохиромжтой.
3. Хуваагдсан бүтэц: Хэлтэс, газар, тэнхимийн бүтэц нь бие биенээсээ хараат бус байдлаар ажилладаг.
4. Хавтгай бүтэц: Ажиллах хүч цөөтэй жижигхэн байгууллагууд хэрэглэдэг.

Нөөцийн менежментийн гол хүчин зүйлс

1. Хүний нөөцийн менежмент: Хүний нөөцийн нэгж нь дараах чиг үүргийг хариуцана.
 - Ажиллах хүчнийг төлөвлөх (эрэлт, нийлүүлэлт);
 - Цалин хөлс, тэтгэмжийн тогтолцоог удирдах;
 - Ажилтныг бүрдүүлэх;
 - Ажилтны сургалт, хөгжил;

Ажилтны мэдлэг ур чадвар;

Ажилтны гүйцэтгэлийн үнэлгээ, урамшууллын менежментийг хянах үүрэгтэй.

2. Дэд бүтэц, орчны менежмент: багш, ажилтан, оюутан зэрэг оролцогч талуудын чанартай үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх, багшлах, суралцах ажлын таатай орчныг бүрдүүлэх;
Стратегийн төлөвлөгөөг дэмжих, тасралтгүй сайжруулах, хөгжлийг дэмжих зорилгоор дэд бүтэц, орчин болон нөөцийн зохион байгуулалтыг оновчтой хийх.
3. Санхүүгийн менежмент: Байгууллага нь алсын хараа, эрхэм зорилгыг дэмжихийн тулд санхүүгийн эрүүл тогтолцоог хангах зорилгоор санхүүгийн нөөц, туршлагаа хянаж, удирдана. Төсөв нь байгууллагын ажиллагааг тооцох, удирдахад хэрэглэдэг санхүүгийн төлөвлөлт юм. Төсвийн хоёр төрөл байна.
 - Орлого, зарлагын эсвэл үйл ажиллагааны төсөв,
 - Үл хөдлөх хөрөнгийн эсвэл хөгжлийн төсөв.
4. Мэдлэгийн менежмент: Мэдлэгийн менежмент нь байгууллагад хэрэгтэй чухал мэдээллүүдийг тодорхойлох, сонгох, зохион байгуулах, тараан дэлгэрүүлэх, дамжуулахад нь туслах үйл явц. Мэдлэг нь асуудал хэрхэн үүссэн, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэж байгааг тодорхойлох явдал мөн. Мэдлэгийн менежмент нь байгууллагын суралцах үйл явц, цаашдын мэдлэг бүтээх үйл явцыг дэмжиж байдаг үйл ажиллагаа болно.

Хэмжигдэхүүн, шалгуур үзүүлэлтүүд

Стратегийн зорилтуудыг хэмжигдэхүйц үйл ажиллагааны төлөвлөгөө болгон хувиргахын тулд хэмжигдэхүүн, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлно. Тэнцвэртэй онооны карт, гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтийг боловсруулж хэрэглэнэ.

СУРГАЛТЫН ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТ

Сургалтын чанарын менежмент нь оюутан суралцагч болон бусад оролцогч талуудын хэрэгцээ шаардлагыг хангах сургалтын хөтөлбөрийн чанар, үнэ цэнэ, уялдаа холбоог тогтоож баталгаажуулахад чиглэгдэнэ. Энэ нь чанартайгаар багшлах, суралцах үйл явцыг загварчлах, сургалтын чанарын менежментийг хэрэгжүүлэх, өөрчлөгдөж буй үйлдвэржилт, оюутны хэрэгцээ, хүлээлтэд нийцүүлэхийн тулд хөтөлбөрт үнэлгээ хийнэ.

Сургалтын чанарын менежментийн зорилго:

Сургалтын хөтөлбөрийн чанарыг сайжруулах, үнэлэх;
Нөөц бололцооны хүрээнд хамгийн сайн туршлагыг оюутанд олгох;
Сул талыг засаж сайжруулахад тохирсон үйл ажиллагааг бий болгох;
Сайн шилдэг туршлагыг тогтоох, түгээх;
Үнэлгээний үйл явц, хөндлөнгийн үнэлгээнд шаардагдах мэдээллийг цуглуулах, шинжилгээ хийх.

Сургалтын чанарын менежментийн тогтолцоог боловсруулах арга

1. Сургалтын чанарын менежментийн үүрэг, зорилгыг тодорхойлох;

2. Сургалтын чанарын менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, арга хэмжээ, аргыг загварчлах;
3. Сургалтын чанарын баталгаажуулалтын бодлого, журам, заавар, үйл явц, арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, хөгжүүлэх;
4. Сургалтын чанарын шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох.

Сургалтын чанарын менежментийн тогтолцооны үе шат, үйл явцууд

Сургалтын чанарын менежментийн тогтолцоо 3 үндсэн үе шат ба үйл явцтай.

Үүнд:

1. Хөтөлбөрийг загварчлах, хөгжүүлэх үе шат ба үйл явц
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат ба үйл явц
3. Хөтөлбөрийг үнэлэх үе шат ба үйл явц



Сургалтын хөтөлбөрт чанарын баталгаажуулалт хийх бүх үйл явцыг дараах системчилсэн бүдүүвчээр төсөөлүүлж болно.



Сургалтын хөтөлбөрт чанарын баталгаажуулалт хийх үйл явцын бүдүүвч

Хөтөлбөрийн менежментийн баг, Хөтөлбөрийн хороо, тэнхимийн үүрэг

Чиг үүргийнхээ хүрээнд хөтөлбөрийн бүх үйл явцыг удирдан зохион байгуулах, уялдаа холбоо, үнэ цэнэ, сайн чанарыг хангахын тулд хөтөлбөрийг боловсруулахад сургалтын манлайллыг үзүүлэн ажиллах.

Сургалтын чанарын менежментийн тогтолцооны үндсэн оролцогч талууд

Боловсрол шинжлэх ухааны яам,
Удирдах зөвлөл,
Захиргааны зөвлөл,
Эрдмийн зөвлөл,
Сургалт эрхэлсэн захирал,
Хөтөлбөрийн хороо,
Салбар, тэнхим,
Ажил олгогч,
Хичээл зохицуулагч,
Хөндлөнгийн шинжээч,
Сургалтын хөтөлбөр,
Хичээлийн үнэлгээний тайлан,
Жил бүрийн хөтөлбөрийн үнэлгээ,
Хөтөлбөрийн удирдлагын мэдээллийн систем,
Дижитал мэдээллийн сан,
Багшлах бүрэлдэхүүн,
Төгсөгчдийн холбоо.

ТАВАН ЖИЛ ТУТМЫН ХӨТӨЛБӨРИЙН ҮНЭЛГЭЭ

- Сургалтын хөтөлбөрийн зохиомж, агуулга, зохион байгуулалт,
- Биет суралцахуйн нөөц,
- Хүний нөөц ба хөгжил,
- Хөтөлбөрийн менежмент, чанарын сайжруулалт,
- Сургах, суралцах, үнэлгээ,
- Оюутны дэмжлэг, гарын авлага.

1. Сургалтын хөтөлбөрийн зохиомж, агуулга, зохион байгуулалт

Сургалтын хөтөлбөр, үйлдвэрийн уялдаа холбоо,
Сургалтын хөтөлбөрийн зорилго,
Хэрэгжилт ба үнэлгээ,
Хөтөлбөрийн тогтмол үнэлгээ,
Кредит цаг,
Магадлан итгэмжлэл олгох боломж,
Хичээлийн өөрчлөлтийн тухай хөтөлбөрийн багийг шинэчлэх.

2. Биет суралцахуйн нөөц

Дэд бүтцийн засвар үйлчилгээ, хүртээмжтэй байдал,
Суралцахуйг дэмжихэд зориулсан,
Суралцахуйн материалын өргөн цар хүрээ ба бэлэн байдал,
Багшлахуй, суралцахуйг дэмжих МТ-ийн нөөцийн бэлэн байдал,
хүртээмжтэй байдал.

3. Хүний нөөц ба хөгжил

Багш нарын мэргэжлийн суурь,

Сургалтын хөтөлбөрийг хүргэх үр ашигтай ур чадвар,
Багшийн сурганы болон мэргэжлийн хөгжил,
Техник технологийн ур чадварыг дээшлүүлэх.

4. Хөтөлбөрийн менежмент, чанарын сайжруулалт

Хөтөлбөрийн зорилгыг үр дүнтэй хэрэгжүүлэх хөтөлбөрийн менежмент,
Сургуулийн стратегийг дэмжих,
Хөтөлбөрийн менежментийн чиг үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэх,
Хөтөлбөрийн менежментийн баг, багш нарын хооронд сайн харилцаа
холбоо.

5. Сургах, суралцах, үнэлгээ

Хөтөлбөрийн зорилго, суралцахуйн үр дүнг багш нарт тодорхой мэдээлэх
Суралцахуйн үр дүнг хэрэгжүүлэхэд тохирсон багшлах, суралцах арга,
үнэлгээг хэрэглэх,
Оюутны ажлын ачаалалд зохицуулж, зохистой хөтөлбөр гаргах,
Үнэлгээг шударга, зөв удирдан зохион байгуулах үйл явц,
Үнэлгээний тухай оюутанд мэдээлэл өгөх (цаг тооцох, шалгуур, жин,
гүйцэтгэл, ахиц).

6. Оюутны дэмжлэг, гарын авлага

Ангийн ганцаарчилсан зөвлөхүүд оюутны сайн сайхны төлөө ажиллах,
Хөтөлбөрийн хувилбарууд, сонгон хичээл, суралцахуйн санаачлагууд,
боломжийн тухай мэдээллийг оюутнуудад өгөх,
Хөтөлбөрийн оюутнуудын ахиц дэвшилд хяналт шинжилгээ хийх, хичээл
үзэх явцад нь тохирох удирдамжийг өгөх,
Мэргэжлийн сонголт, цаашдын боловсрол, хувь хүний асуудалд зөвлөгөө
өгөх.

ҮЙЛДВЭРИЙН ОРОЛЦОО

Үйлдвэр, их сургууль хоорондын хамтын ажиллагаа дараах зорилготой:

- Үйлдвэрийн хэрэгцээнд нийцсэн үнэ цэнэтэй боловсролын үр дүнд хүрэх нөхцлийг бүрдүүлэх;
- Өөрчлөгдөн буй боловсролын салбартай уялдуулан шинэ зах зээл рүү гаргах, оруулах;
- Үйлдвэрийн салбартай оюутан, багш ажилтан хамтран ажиллах арга замыг бүрдүүлэх; Судлаачид шинэ санаа олоход гадны судлаачид, компаниудын оролцоог бий болгох;
- Их сургуулийн R&D –ийн хүчин чармайлтыг нэмэгдүүлж инновацийн эдийн засгийн гол хөдөлгөх хүчийг бий болгох.

Үйлдвэр, их сургуулийн хамтын ажиллагааны төрөл:

1. Судалгааны дэмжэг

- Санхүү, тоног төхөөрөмжөөр хангах
- Лабораторийг сайжруулах
- Оюутанд тэтгэлэг олгох
- Гарааны санхүүжилт өгөх

2. Хамтарсан судалгаа

- Гэрээт судалгаа
- Хувь судлаачид: Зорилтот судалгааны төсөл дээр ажиллах нэг компани
- Бүлгийн зохион байгуулалт: Нэгээс олон багш, үйлдвэрийн компани
- Үйлдвэрийн нэн тэргүүний асуудлыг шийдэх зорилготой зөвлөх үйлчилгээ үзүүлэх багш, бүлэг

3. Мэдлэг дамжуулах

- Хамтарсан боловсрол
- Сургалтын хөтөлбөр боловсруулах
- Оюутны дадлага
- Судалгааны өгүүллэгийн хамтран зохиогч болох
- Ажилтнуудын харилцаа

4. Технологи дамжуулах

Их сургууль чиглүүлсэн судалгаа, аж үйлдвэрийн мэдлэг
Үйлдвэрийн нэн тэргүүний болон тусгай асуудлуудыг шийдэх
Зах зээлд эрэлттэй байгаа технологийг арилжаанд гаргах

ГАДААД БА ДОТООД ҮЙЛЧИЛГЭЭ

ШМТДС-ийн гадаад ба дотоод үйлчилгээ нь багш ажилтан, оюутны оюун санаа, соёл, нийгмийн зохистой орчинг бүрдүүлэх, сургуулийн нэр хүндийг нэмэгдүүлэх зорилготой. Үүнд:

1. Оюутан багш ажилтны сургуулийн амьдрал туршлагыг баяжуулах тогтолцоо, дэд бүтэц орчинг бүрдүүлэх
2. Оюутанд суралцахуйн орчинг бүтээж өгөх сургалтын үйлчилгээ, дэмжлэгийг бий болгох
3. Оюутан багш ажилтанд зориулсан өргөн цар хүрээтэй оюун санаа соёл, нийгмийн орчинг бүрдүүлэх, хөгжүүлэх
4. Байгууллагын нийгэм дэх байр суурь, үүрэг ролийг сайжруулах, олон нийтийн үйлчилгээг оролцооны үйл ажиллагаануудыг бий болгох

Үйлчилгээ нь хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй байна:

- Байгууллагын өөрийн зорьж буй оюун санаа, соёл, нийгмийн орчинг бүтээх, хадгалах дотоод үйлчилгээ;
- Орон нутгийн, олон нийт, ажил олгогч нар, аж үйлдвэр, бүс нутаг, үндэсний олон нийтийн дотор ДББ –ын байр суурийг бэхжүүлэх гадаад үйлчилгээ

ШМТДС-ИЙН ЧАНАРЫН БОДЛОГО

ШМТДС-ийн алсын хараа, эрхэм зорилгыг хэрэгжүүлэх тэргүүлэх чиглэлүүдэд чанартай, хэвшмэл, хэмжигдэхүйц үйл явцуудыг тодорхойлж хянах замаар ШМТДС-ийн оролцогч талуудын хариуцлагыг дээшлүүлж ажлын үр дүнг сайжруулахад оршино.

ШМТДС-ИЙН ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

ШМТДС-ийн чанарын дотоод баталгаажуулалтын алба, түүний бүрэлдэхүүнийг Захирлын тушаалаар томилж ажиллуулна.

Чанарын дотоод баталгаажуулалтын албаны чиг үүрэг:

- ШМТДС-ийн чанарын удирдлагын тогтолцооны нэгдмэл байдал, тасралтгүй сайжруулалтыг хангах үйл явцын урсгалыг хянах;
- Суралцагчийн хэрэгцээ ба хүлээлтийг хангахад анхаарч, тэдний мэдээллийг байнга шинэчлэх;
- Чанар, сайжруулалтын олон улсын стандартыг туршин нэвтрүүлж, шаардлагад нийцүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;
- ШМТДС-ийн чанарын бодлогыг байгууллагын хэмжээнд мэдээллэн, ойлгуулах, сонирхогч талуудад боломжит хэмжээнд мэдээллэх;
- ШМТДС-ийн чанарын зорилтыг тодорхойлох, тэдгээрийн биелэлтийг хянах;
- Гадаад, дотоод аудитыг зохион байгуулах ажлыг хариуцах;
- Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний дотоод чанарын хяналт, баталгаажуулалтыг зохион байгуулах;
- Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээнд нөлөөлөх эрсдэл, боломжит SWOT шинжилгээ хийх;
- Чанарын удирдлагын тогтолцооны гүйцэтгэл болон сайжруулах боломжуудын тухай сургуулийн удирдлагад тайлагнах;
- Их сургуулийн бодлогын баримт бичгийн хөтлөлт, хадгалалтанд хяналт тавьж ажиллах;
- Чанарын соёлыг нийт багш ажилтан, суралцагчдад түгээх, сургалт, сурталчилгаа хийх.

Бүх багш, ажилтны чиг үүрэг:

- Хариуцсан ажил, үүргийг холбогдох хууль тогтоомж, чанарын удирдлагын тогтолцооны олон улсын стандарт, сургуулийн дотоод дүрэм, журмын шаардлагад нийцүүлж ажиллах;
- Чанарын сайжруулалтын арга хэрэгслүүд болох үйл явцын арга, PDCA тасралтгүй сайжруулалтын мөчлөг, эрсдэлд суурилсан сэтгэлгээг ойлгож, бүх үйл ажиллагаанд хэрэглэх;
- Чанарын удирдлагын тогтолцооны гүйцэтгэл, сайжруулах боломжийн талаар сургуулийн удирдлага болон чанар хариуцсан нэгж, ажилтанд мэдээллэх;
- Суралцагч болон үйлчлүүлэгчийн хэрэгцээ ба хүлээлтийг хангахыг зорьж ажиллах;
- Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг эрхэмлэж, гүйцэтгэлд хариуцлага хүлээх;
- Аливаа үл тохирлыг мэдээллэж, авсан арга хэмжээг тайлагнах;
- Сургуулийн нийгмийн хариуцлагын бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлж, мэдээлэл солилцоог дэмжиж ажиллах;
- Сургуулийн гадаад, дотоод харилцаа холбоог шуурхай, хариуцлагатай зохион байгуулах;
- ШМТДС-ийн чанарын бодлого, зорилттой уялдуулан харьяа тэнхим, нэгжийн чанарын зорилтыг тодорхойлж, хэрэгжүүлэх;

- Багшлах, суралцах орчныг тусгай хэрэгцээт болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын шаардлагыг тодорхойлж, хангах ;
- Чанарын удирдлагын тогтолцооны гадаад, дотоод аудитад бэлтгэж, оролцох.

БАРИМТЖУУЛАХ МЭДЭЭЛЭЛ:

ШМТДС -ийн зохион байгуулалтын бүтцийн зураг

Ажлын байрны тодорхойлолт

ШМТДС -ийн Хөдөлмөрийн дотоод журам

ШМТДС -ийн Багш, ажилтны ёс зүйн дүрэм

ШМТДС -ийн Багш, ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлж, урамшуулах журам

Тэнхимийн үйл ажиллагааг зохицуулах журам

ШМТДС-ИЙН ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ

ШМТДС -ийн Чанарын дотоод баталгаажуулалтын алба нь эрсдэл болон боломжид чиглэсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

Эрсдэл, боломжийг илрүүлж, тодорхойлохдоо байгууллагын дотоод хүчин зүйлсийг шинжлэх зорилготой SWOT, байгууллагын гадаад хүчин зүйлсийг шинжлэх зорилготой PESTLE шинжилгээ хэрэглэнэ. Эдгээр шинжилгээг хийхдээ дараах зүйлст анхаарал хандуулна.

- Чанарын зорьсон үр дүнд хүрэхэд нөлөөлөх байдал;
- Байгууллагын үйл ажиллагааны үр шимийг сайжруулах, шинэ боломжуудыг бий болгох;
- Болзошгүй сөрөг үр дагавар, аюулыг багасгах эсвэл сэргийлэх;
- Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний нийцлийг хангах;
- Суралцагч, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхийн тулд сайжруулалт хийх.

Тодорхойлсон эрсдэл, боломжийг дараах байдлаар ангилна:

- Нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын эрсдэл,
- Санхүү, төсвийн эрсдэл,
- Орчин, дэд бүтцийн эрсдэл,
- Мэдээлэл технологийн эрсдэл,
- Эрдэм шинжилгээ, судалгааны эрсдэл,
- Сургалтын үйл ажиллагааны эрсдэл,
- Суралцагчтай холбогдох эрсдэл,
- Хүний нөөцийн эрсдэл,
- Аюулгүй байдлын эрсдэл,
- Гадаад хүчин зүйлсийн буюу бусдаас хамаарах эрсдэл.

ШМТДС-ийн чанарын эрсдлийн шинжилгээ хийнэ. Үйл ажиллагааны явцад тохиолдож болох тодорхой эрсдлийн үзүүлэх нөлөөллийг хэмжиж тодорхойлоход чиглэгдэнэ. Үр дүнг эрсдлийн үнэлгээний матрицаар үнэлж оролцогч талуудад үл

мэдэгдэх аюулыг мэдээллэнэ. Матрицын үнэлгээний зорилго нь эрсдлийн зэргийг тодорхойлоход оршино.

		МАГАДЛАЛ				
		1 МАШ ХОВОР	2 БАГА	3 ЗАРИМДАА	4 ИХ	5 БАЙНГА
ҮР ДАГАВАР	5 МАШ ИХ	5	10	15	20	25
	4 ИХ	4	8	12	16	20
	3 ДУНД ЗЭРЭГ	3	6	9	12	15
	2 БАГА	2	2	6	8	10
	1 МАШ БАГА	1	2	3	4	5

ЭРСДЭЛ = ■ БАГА ■ ДУНД ЗЭРЭГ ■ ИХ ■ АЮУЛТАЙ